

Article

Definition of innovation activities of the organization, its quality and contentJargal Galaa^{1*}

¹ Department of Business Administration, School of Economics and Business, International Ulaanbaatar University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: jargal.g@ulaanbaatar.edu.mn

 <https://orcid.org/0009-0009-5921-7486>

Received: 01 November 2025

Accepted: 12 December 2025

Published online: 31 December 2025

Abstract

Nowadays, the knowledge economy has become the trend of global development. In this context, innovation activities to transform knowledge into effective use have intensified significantly, and strengthening the innovation capacity of any economic entity has become crucial for increasing competitiveness. In particular, for organizations and enterprises, it is necessary to activate innovation activities, optimize their management and organization, and increase results and benefits. This work discusses the content of innovation activities of enterprises and organizations, the content of some key concepts related to it, and the scope, types, and classifications of innovation activities at the organizational level.

Keywords: Organizational innovation activities, stages, categories, types and forms



© 2025, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator.

<https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Байгууллагын инновацын үйл ажиллагаа, түүний мөн чанар, агуулгын тодорхойлолт

Галаагийн Жаргал¹

¹ Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Эдийн засаг бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын тэнхим, Улаанбаатар хот, Монгол улс

Хураангуй

Орчин үед мэдлэгийн эдийн засаг дэлхий дахины хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох боллоо. Энэ нөхцөлд мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргах инновацын үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, эдийн засгийн аливаа субъектийн хувьд инновацын чадавхийг бэхжүүлэх нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой болж байна. Ялангуяа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувьд инновацын үйл ажиллагааг идэвхжүүлэн, түүний удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, үр дүн, үр өгөөжийг нэмэгдүүлэх явдал өнөөгийн цаг үеийн шаардлага болоод байна. Уг бүтээлд аж ахуйн нэгж, байгууллагын инновацын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой зарим гол ойлголтуудын агуулга, байгууллагын түвшин дэх инновацын үйл ажиллагааны хамрах хүрээ, төрөл хэлбэр, ангиллын асуудлыг хөндөн авч үзлээ.

Түлхүүр үг: Байгууллагын инновацын үйл ажиллагаа, үе шат, ангилал, төрөл, хэлбэр

Удиртгал

Өнөө үед бизнесийн байгууллагууд нийгэм-эдийн засгийн түргэн өөрчлөгддөг, хямралын байнгын эрсдэл бүхий ихээхэн хувьсамтгай орчинд үйл ажиллагаа явуулж байна. Ийм нөхцөлд тэсэж үлдэхийн тулд аливаа байгууллагад бодлого, үйл ажиллагаагаа тасралтгүй шинэчлэх шаардлага тулгарах боллоо. Иймээс үйлдвэр аж ахуйн газруудын хувьд инновац нь байгууллагын үр ашиг, бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, урт хугацаанд оршин тогтнох, тогтвортой хөгжлийн хангах нэг гол хүчин зүйл болж байна. Инновацыг нэвтрүүлснээр аж ахуйн нэгж, байгууллагуудад уламжлалт давуу талаа бататгахын зэрэгцээ, шинэ, харьцангуй давуу тал, урт хугацааны хөгжлийн боломжуудыг бий болгох, улмаар бүтээмж, үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бололцоог бүрдүүлнэ. Энэ талаар мөн Ослогийн удирдамжид: “инновац бол үйлдвэрлэл, бүтээмжийн өсөлтийн гол хүчин зүйл гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрөх болсон”, “технологийн дэвшил, мэдээллийн урсгал нэмэгдсэний үр дүнд мэдлэг- эдийн засгийн өсөлт, инновацын гол хөдөлгөгч хүч болдог нь улам бүр ойлгомжтой болсоор байна”, “дэлхийн эдийн засаг хөгжихийн хэрээр инновацын үйл ажиллагаа ч мөн хувьсан өөрчлөгдөж, даяаршлын үр нөлөөгөөр мэдээлэл олж авах, шинэ зах зээлд нэвтрэх компаниудын боломж үлэмж нэмэгдэж байна” гэж дурджээ (OECD & Eurostat. 2005).

Инновацыг хөгжүүлэх, түүнийг судлах хэрэгцээ шаардлага ихээхэн нэмэгдээд байгаа манай орны нөхцөлд инновацыг гардан хэрэгжүүлдэг гол субъект болох аж ахуйн нэгж байгууллагуудын инновацын үйл ажиллагааны агуулга, хамрах хүрээг зөв оновчтой тодорхойлох, энэ талын ойлголтыг нэр мөр болгох шаардлагатай байна.

Судалгааны арга зүйн чиг баримтлал, аргачлал

Инновац, инновацын үйл ажиллагааны мөн чанар, агуулгыг тодорхойлох чиглэлээр явуулсан судалгааны хүрээнд баримт бичгийн судалгаа, агуулгын шинжилгээний аргуудыг ашиглав.

Өмнөх судлаачдын судалгаа, бүтээлүүд болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан шинжлэх ухаан технологи, инновацын хүрээнд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга зүйн зөвлөмж- удирдамжууд, инновацын тухай хууль тогтоомжид тусгагдсан “инновац”, “инновацын үйл ажиллагаа”, тэдгээртэй холбогдох зарим гол ойлголтуудын тодорхойлолтыг судалж, агуулгын дүн шинжилгээ хийсэн болно.

Аж ахуйн нэгж, байгууллагын инновацын үйл ажиллагаа: агуулга, хамрах хүрээ

“Инновац” гэсэн ойлголтын утга агуулгыг эдийн засгийн онол практикт олон талтайгаар тодорхойлон, авч үзэж иржээ. Анхлан инновацын онолыг үндэслэгч И.Шумпетер түүнийг орчин үеийн агуулгаар авч үзсэн бөгөөд “инновац бол үйлдвэрлэлийн технологи болон аж ахуйн нэгжийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлсэн шинэ зүйл, өөрөөр хэлбэл, шинэ материал, процесс, үйл ажиллагаа, зохион байгуулалтын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх, шинэ зах зээлийн эзэмших зэргээр аливаа шинэ зүйлийг арилжааны эргэлтэд оруулсны үр дүн” хэмээн тодорхойлсон байдаг (Schumpeter, J. 1993).

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргасан Шинжлэх ухаан технологи, инновац судалгааны удирдамжуудад инновацын тодорхойлолтуудыг дараах байдлаар тусгажээ. Тухайлбал, 1993 онд нийтлэгдсэн Фраскатын удирдамжинд инновацыг “...шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессийг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулсан үйл ажиллагааны эцсийн үр дүн...” гэж тусгасан (OECD. Frascati manual. 2002) бол 1992 онд анхлан гаргасан Ослогийн удирдамжинд: “инновац гэдэг нь шинэ, эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн (бараа, үйлчилгээ) болон үйл явц(процесс), маркетингийн шинэ арга хэрэгсэл, түүнчлэн бизнесийн практик үйл ажиллагаа, ажлын байр, гадаад харилцаа түншлэлийн хүрээнд нэвтрүүлсэн зохион байгуулалтын шинэ арга, хэлбэр” хэмээн заажээ(OECD & Eurostat. 2005).

Манай орны хувьд инновацын мөн чанар агуулгыг тодорхойлох чиглэлээр 1990 оны сүүлч үеэс тодорхой судалгааны ажлууд (Оюунцэцэг, Л. 2009) хийгдэх болсны зэрэгцээ төрийн бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд уг ойлголт тусгаад байна. Тухайлбал, 2006 онд шинэчлэн батлагдсан Монгол улсын Шинжлэх ухаан технологийн тухай хуульд: “Инновац гэж эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа” гэж тусгасан (Монгол Улсын Их Хурал, 2006). бол 2012 онд батлагдсан Монгол улсын Инновацын тухай хуульд: “Инновац гэж мэдлэгийг баялаг болгох хувиргах цогц үйл ажиллагаа” гэж заасан байна (Монгол Улсын Их Хурал, 2012).

Ерөнхийдөө инновац бол нийгэм, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй хэрэглээ болон үйлдвэрлэл, практикт нэвтэрсэн, эсвэл нэвтрэх боломжтой шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи, түүнчлэн маркетинг-борлуулалт, удирдлага-зохион байгуулалт, санхүү-эдийн засгийн болон бусад дэвшилтэт шийдэл мөн (Оюунцэцэг, Л. 2009).

Манай орны хувьд хууль тогтоомжид тусгасан инновацын ойлголтын агуулгыг эргэн харж, олон улсын удирдамжид заасан нийтлэг тодорхойлолтыг харгалзан шинээр томъёолох шаардлагатай хэмээн үзэж, дараах агуулгаар тусгах саналыг дэвшүүлж байна. Үүнд: “Инновац” гэж мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл ажиллагааны үр дүн болох шинэ, эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйл явц, технологи, маркетинг, зохион байгуулалтын шинэ арга, дэвшилтэт шийдэл”-ийг хэлнэ.

Түүнчлэн дээр дурдсан Ослогийн удирдамжид инновацын шалгуур, ангилал, байгууллагын түвшний инновац, инновацын үйл ажиллагааны талаар тодорхой тусгасан байдаг ба аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд инновацын дараах 4 төрлийг авч үзэхээр заасан байна(OECD & Eurostat. 2005). Үүнд:

1. Бүтээгдэхүүний инновац (product innovations);
2. Процессын инновац (process innovations);
3. Зохион байгуулалтын инновац (organisational innovations);
4. Маркетингийн инновац (marketing innovations);

Ер нь инновацад тавигдах 3 гол шаардлага нь:

Нэгд, шинжлэх ухаан технологийн хувьд шинэлэг байх;

Хоёрт, практикт хэрэгжүүлэх болон үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой байх;

Гуравт, арилжаалах боломжтой, өөрөөр хэлбэл, зах зээлд борлогдон, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангах чадвартай байх гэж үзэж болно.

Дээрхээс үзэхэд шинэлэг байдлын зэрэг нь инновацын ангиллын нэг чухал шалгуур болох ба үүгээр тухайн төрлийн инновацын хамрах хүрээ тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл, байгууллагын хувьд шинэ, салбар, бүсийн хувьд шинэ, улс орны хувьд шинэ, эсвэл дэлхийн түвшинд шинэ гэсэн шалгуур нь аль нэг нэг шинэ зүйлийг ямар хүрээнд инновацад хамруулах үндэслэл болдог гэсэн үг юм. Энэ талаар Ослогийн удирдамжийн 2 дахь хэвлэлд мөн тусгажээ (OECD, Oslo manual. 2002).

			ИННОВАЦ			ИННОВАЦ БИШ
			максимум	дундаж	минимум	
			Дэлхийд шинэ	(a)	ААН-д шинэ	
Технологийн инновац: бүтээгдэхүүн, процесс	Технологийн хувьд цоо шинэ	Бүтээгдэхүүн				
		Үйлдвэрлэлийн процесс				
		Борлуулалтын процесс				
	Технологийн хувьд шинэлэг (эрс сайжирсан)	Бүтээгдэхүүн				
		Үйлдвэрлэлийн процесс				
		Борлуулалтын процесс				
Бусад	Шинэ ба шинэлэг	Зохион байгуулалт				
Инновац биш	Шинэ ба шинэлэг бус, онцын сайжралт, бүтээлч өөрчлөлт хийгдээгүй	Бүтээгдэхүүн				
		Үйлдвэрлэлийн процесс				
		Борлуулалтын процесс				
		Зохион байгуулалт				

Зураг 1. Шинэлэг байдлын зэрэг ба инновацын төрөл

Тайлбар: (a)- газар зүйн хувьд тодорхойлж болно(салбар, бүс нутаг, улс орны хувьд шинэ г.м.)

Эх үүсвэр: (OECD, Frascati manual. 2002, p. 36)

Цаашилбал, дээрх удирдамжийн шинэчилсэн 3 дахь хэвлэлийн 8-р зүйлд “Компаний хувьд шинэ” гэдгийг инновацад тавигдах наад захын шаардлага болгон ашиглах 2 үндсэн шалтгааны талаар заажээ (OECD & Eurostat. 2005). Эдгээр нь:

Нэгд, инновацыг нэвтрүүлж, нутагшуулах нь байгууллагын инновацын тогтолцооны хувьд чухал бөгөөд энэ нь тухайн компанийг чиглэсэн мэдлэгийн урсгалыг илэрхийлдэг. Түүнээс гадна, инновацыг нэвтрүүлэх явц дахь суралцах үйл ажиллагаа цаашдаа тухайн инновацыг улам боловсронгуй болгон хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйл явц болон бусад инновацыг бий болгоход хөтөлдөг.

Хоёрт, эдийн засгийн үйл ажиллагаанд инновацын үзүүлэх үр нөлөө нь инновацын тархалтаас үүдэлтэй. Тархалт нь “компаний хувь шинэ” гэсэн шалгуураар инновацыг тодорхойлох боломж олгодог.

Дээрхээс үндэслэн дүгнэвэл, аж ахуйн нэгж байгууллагын түвшний инновац гэдэгт тухайн байгууллагын хувьд шинээр үйлдвэрлэсэн, эсвэл нэвтрүүлсэн шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи, мөн маркетинг-борлуулалт, удирдлага-зохион байгуулалт, санхүү- эдийн засгийн болон бусад дэвшилтэт шийдлийг хамруулж болно.

Инновацын ангиллын шалгуур болон үр дүн, үр ашгийн үзүүлэлтийг тодорхойлсон үр дүнг энэхүү ажилд хавсаргав (хавсралт 1).

“Инновацын үйл ажиллагаа” гэсэн ойлголтын тухайд Ослогийн удирдамжийн 40 дэх зүйлд: “Инновацын үйл ажиллагаанд бүхий л шинжлэх ухаан, технологи, зохион байгуулалтын, санхүүгийн болон арилжааны арга хэмжээ хамрагдах бөгөөд эдгээр нь инновацыг хэрэгжүүлэхэд шууд ба шууд бусаар нөлөөлнө. Эдгээр үйл ажиллагааны зарим нэг нь инновацын шинжтэй байдаг бол нөгөө хэсэг нь шинэлэг биш байж болох ч инновацыг хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал байдаг” гэж заажээ. Цаашилбал, өмнө дурдсан баримт бичгийн 41-р зүйлд “Инновацыг бий болгох, нэвтрүүлэх үйл явц нь судалгаа ба хөгжүүлэлт(R&D)-ийн үйл ажиллагаанд хамаарахгүй үйлдвэрлэлийн бэлтгэл ажиллагаа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлт зэрэг үе шатуудыг агуулдаг. Мөн шинэлэг байдлын түвшин багатай туслах шинжийн үйл ажиллагаа, тухайлбал, сургалт, маркетингийн бэлтгэл үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйл явцын инновацад үл хамаарах маркетинг болон зохион байгуулалтын шинэ аргууд багтана. Түүнчлэн инновацын үйл ажиллагаанд гаднаас мэдлэг болон хөрөнгө капитал олж авах гэх мэт судалгаа ба хөгжүүлэлтийн бус үйл ажиллагаа багтдаг” гэж тусгажээ (OECD & Eurostat. 2005).

Харин судлаачдын зүгээс “инновацын үйл ажиллагаа”, “инновацын үйл явц (процесс)” гэсэн ойлголтуудыг ялгаатайгаар тодорхойлж авч үзэх саналыг дэвшүүлсэн байна.

Тухайлбал, А. М.Мухамедьяров “...инновацын үйл ажиллагаа-шинэ зүйлсийг бүтээн бий болгоход чиглэсэн хайгуулын болон хавсарга судалгаа, төсөл-зохион бүтээлтийн ба технологийн боловсруулалт, туршилтын болон үйлдвэрлэл-ашиглалтын зэрэг төрөл бүрийн ажлуудаас бүрдэх бол “...инновацын процесс – шинэ бүтээл«судалгаа-үйлдвэрлэл-хэрэглээ» гэсэн мөчлөгөөр хэрэгжих процесс” гэжээ (Мухамедьяров, 2004).

Харин А. Е. Абрамешин, Т. П. Воронина, О. П. Молчанова болон бусад судлаачдын бүтээлд “инновацын үйл ажиллагаа”-эрдэм шинжилгээ, туршилт-зохион бүтээлтийн ажлын болон шинжлэх ухаан технологийн дэвшлийн үр дүнг шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн, технологийн процесс бий болгох зорилгоор ашиглах, практикт нэвтрүүлэх, зах зээлд

арилжаалах, эдгээртэй холбоотой судалгаа шинжилгээ, боловсруулалт, туршилт зохион бүтээлтийн нэмэлт ажлуудыг гүйцэтгэх” гэж, харин “инновацын процесс нь ...шинэ зүйлс (инновац)-ыг бий болгох, түгээн дэлгэрүүлэх процесс” гэж тодорхойлжээ (Молчанова, 2001).

В.А. Швандер болон бусад судлаачид инновацын үйл ажиллагааг- “...үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн(таваар, үйлчилгээ)-ний нэр төрлийг олшруулах, шинэчлэх, чанарыг сайжруулах, тэдгээрийн технологийг боловсронгуй болгох зорилгоор эрдэм шинжилгээ, боловсруулалтын ажлын үр дүнг ашиглах, арилжаалах, улмаар гадаад дотоодын зах зээлд борлуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа...” гэсэн бол “инновацын процесийг ...шинжлэх ухааны мэдлэгийг инновац болгон хувиргахад чиглэх бөгөөд шинэ санааг бодит бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээ болгон хувиргаж, практикт нэвтрүүлж хэрэглээ болгох хүртэл шат дараалалтай явагдах бөгөөд шинжлэх ухаан технологийн дэвшлээс ялгагдах онцлог нь зөвхөн нэвтрүүлж, зах зээлд анхлан гаргаад зогсохгүй, төслийн хүчин чадлыг бүрэн эзэмших хүртэл үргэлжилнэ...” гэж үзсэн байна (Швандер, 2006).

Харин “Инновацын үйл ажиллагааны тухай” Казакстан улсын хуульд “...инновацын үйл ажиллагаа - эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхүйц үр дүнд хүргэх шинэ санаа, нээлт бүтээл, технологи, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл ба нийгмийн удирдлагын хүрээнд нэвтрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа” гэж заасан (Kazakshtan, 2002) бол Украйны хуульд инновацын үйл ажиллагааг “... эрдэм шинжилгээний судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнг нэвтрүүлж, арилжаалах болон шинэ, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад чиглэсэн үйл ажиллагаа” гэсэн агуулгаар тусгажээ (Ukraine, 1997).

Дээрх тодорхойлолтуудыг арга зүйн талаас харьцуулан судалж үзэхэд судлаачид, “инновацын үйл ажиллагаа” гэсэн ойлголтыг авч үзэхдээ 3 үндсэн хандлагыг баримталсан байна. Үүнд:

1. Инновацын үйл ажиллагааг эрдэм шинжилгээ судалгааны ажил, туршилт- зохион бүтээлт, боловсруулалт, шинжлэх ухаан-техникийн ололтын үр дүн (шинэ санаа, шинжлэх ухааны мэдлэг, технологи ба бусад)-г ашиглах, арилжаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа гэж үзсэн;

2. Инновацын үйл ажиллагааг шинэ зүйлийг бий болгоход чиглэсэн, эрэл хайгуулын болон хавсарга судалгаа шинжилгээ, төсөл-зохион бүтээлтийн болон технологийн боловсруулалт, туршилт-судалгаа, үйлдвэрлэл-ашиглалтын шинжтэй төрөл бүрийн ажил (эсвэл) үйлчилгээ гэж үзсэн;

3. Инновацын үйл ажиллагааг шинэ санаа, шинжлэх ухааны мэдлэгийг дамжуулан, зах зээлд эрэлт хэрэгцээтэй шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн процесс болгон хувиргах үйл ажиллагаа, эсвэл шат дараалсан үйлдлүүдийн цогц гэж үзсэн;

Судалгааны үр дүнд тулгуурлан “инновацын үйл ажиллагаа (Innovation Activity)-г мэдлэгийг хэрэглээний эргэлтэнд оруулж, арилжаалахад чиглэгдсэн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, зохион байгуулалт, санхүү, маркетингийн арга хэмжээнүүдийн цогц” гэсэн агуулгаар тодорхойлж болохоор байна. Инновацын үйл ажиллагаа нь шинжлэх ухаан(судалгаа, шинжилгээ), судалгаа ба хөгжүүлэлт (R&D), технологи нэвтрүүлэлт, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, санхүүжилт болон арилжааны зэрэг үе шатуудаас бүрддэг.

Түүнчлэн инновацын үйл ажиллагаатай холбоотой зарим гол ойлголтуудын агуулгыг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Тухайлбал:

- “Инновацын процесс (Innovation process)-Шинэ зүйл (инновац)-ыг бий болгох, нэвтрүүлж, хэрэглээ болгох, түгээн дэлгэрүүлэх үйл явц.

- “Инновацийн бүтээгдэхүүн (Innovation product) – Инновацийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, арилжаалахад чиглэсэн болон шинээр бий болгосон, шинэчлэн сайжруулсан бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ.
- “Инновацийн төсөл (Innovation project)-Тодорхой цаг хугацаанд явагдах инновацийн үйл ажиллагаа, эсвэл инновацийн процессыг тодорхой үр дүнд хүргэхэд чиглэсэн арга хэмжээг тусгасан баримт бичиг”.
- “Инновацийн хөтөлбөр (Innovation programme) - Зорилго, зорилт, объект, газар зүйн байршилтаар нэгдмэл, нөөц, хариуцан гүйцэтгэгч, цаг хугацааны хувьд тодорхой болж, зохицуулагдсан инновацийн төсөл, арга хэмжээнүүдийн цогц”. “Инновацийн зардал (Cost of Innovation) – инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулсан нөөц, хөрөнгийн мөнгөн илэрхийлэл”.
- “Инновацийн хөрөнгө оруулалт (Investment in Innovation) – инновацийг нэвтрүүлэх, инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд оруулсан хөрөнгө”.

Аж ахуйн нэгж, байгууллагын инновацийн үйл ажиллагаанд саад тотгор учруулдаг хэд хэдэн хүчин зүйл байдаг талаар Ослогийн удирдамжийн 45 дахь зүйлд заасан байдаг (OECD & Eurostat, 2005). Үүнд, өндөр үнэ, өртөг, зах зээлийн эрэлтгүй байдал зэрэг эдийн засгийн хүчин зүйлс, түүнчлэн, ур чадвартай хүний нөөцийн хомсдол, мэдлэгийн хангалтгүй байдал гэх мэт тухайн байгууллагын онцлог хүчин зүйлс, мөн эрх зүйн зохицуулалт болон татвар зэрэг хууль эрх зүйн хүчин зүйлүүд хамрагдана. Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд инновацийн үзүүлэх үр нөлөөний талаар дээрх удирдамжид “Байгууллага/компаний гүйцэтгэлд инновацийн үзүүлэх үр нөлөө нь борлуулалтын хэмжээ, зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх, улмаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх хүрээнд олон талаар илэрдэг” хэмээн заасан ба харин үндэсний эдийн засаг, салбарын хэмжээнд үзүүлэх нөлөөллийн чухал илрэлүүдэд олон улсын түвшинд өрсөлдөх чадвар дээшлэх, үндсэн хүчин зүйлсийн бүтээмж (Total factor productivity) өсөх, байгууллагуудын инновацийн талаарх мэдлэг сайжрах, бизнесийн сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээ нэмэгдэх зэргийг хамруулж болно” гэж дурджээ ((OECD & Eurostat, 2005, 48 дахь зүйл).

Түүнчлэн инновацийн судалгаа явуулах цаг хугацааны хамрах хүрээний тухайд уг удирдамжийн 479-р зүйлд “судалгаанд оролцогчдыг хооронд нь харьцуулах боломжийг хангахын тулд судалгааны инновацийн тухай асуултуудад **ажиглалтын хугацаа** тогтоож өгөх ёстой. Инновацийн судалгааны ажиглалтын хугацаа 3 жилээс ихгүй бөгөөд 1 жилээс багагүй байх нь зүйтэй” гэж заасан (OECD & Eurostat, 2005). Энэ нь инновацийн хөгжил ихээхэн түргэн хурдацтай байдагтай холбоотой юм.

Дүгнэлт

1. Орчин үед аж ахуйн нэгж, байгууллагууд нийгэм-эдийн засгийн түргэн өөрчлөлтийн, ихээхэн хувьсамтгай орчинд үйл ажиллагаа явуулах болсноос үүдэн өрсөлдөөн, зах зээлд тэсэж үлдэхийн тулд бодлого, үйл ажиллагаагаа тасралтгүй шинэчлэх, инновацийг цаг алдалгүй нэвтрүүлэх шаардлага тулгарах боллоо. Инновац нь байгууллагын үр ашиг, бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, урт хугацаанд оршин тогтнох, тогтвортой хөгжлийн хангах нэг гол хүчин зүйл болж, үүнийг нэвтрүүлснээр аж ахуйн нэгжүүдэд уламжлалт давуу талаа бататгахын зэрэгцээ, шинэ, харьцангуй давуу тал олж авах, урт хугацааны хөгжлийн боломжуудыг бий болгох, улмаар бүтээмж, үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бололцоо бүрдэнэ.

2. Инновацыг хөгжүүлэх, түүнийг судлах хэрэгцээ шаардлага ихээхэн нэмэгдээд байгаа манай орны өнөөгийн нөхцөлд инновацыг гардан хэрэгжүүлдэг гол субъект болох аж ахуйн нэгж байгууллагуудын инновацын үйл ажиллагааны агуулга, хамрах хүрээг зөв оновчтой тодорхойлох, энэ талын ойлголтыг нэр мөр болгох шаардлагатай байна. Иймд энэ чиглэлээр бид судалгаа явуулж байгаа ба үүний үр дүнд тулгуурлан “инновацын үйл ажиллагаа (Innovation Activity)-г мэдлэгийг хэрэглээний эргэлтэд оруулж, арилжаалахад чиглэгдсэн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, зохион байгуулалт, санхүү, маркетингийн арга хэмжээнүүдийн цогц” гэсэн агуулгаар тодорхойлох санал дэвшүүлж байгаа болно.

3. Инновацыг нэвтрүүлсний үр дүн, үр ашгийг Эдийн засгийн, Шинжлэх ухаан - технологийн, Экологийн, Нийгмийн болон эдгээрийн хосолмол/ интеграл үзүүлэлтүүдээр илэрхийлж, тооцох боломжтой (OECD, Frascati manual 2002; Оюунцэцэг Л. 2009; Монгол Улсын Их Хурал. 2006; Монгол Улсын Их Хурал. 2012; Мухамедьяров, 2004; Молчанова, 2001; Швандер, 2006; Kazakshtan, 2002; Ukraine, 1997).

Ашигласан материалын жагсаалт

- Молчанова, О. П. (2001). *Инновационный менеджмент*. Москва.
- Мухамедьяров, А. М. (2004). *Инновационный менеджмент*. Инфра-М.
- Монгол Улсын Их Хурал. (2006). *Шинжлэх ухаан, технологийн тухай хууль*.
- Монгол Улсын Их Хурал. (2012). *Инновацын тухай хууль*.
- OECD. (2002). *Frascati manual: Proposed standard practice for surveys on research and experimental development*. OECD Publishing.
- OECD & Eurostat. (2005). *Oslo manual: Guidelines for collecting and interpreting innovation data* (3rd ed.). OECD Publishing.
- Оюунцэцэг, Л. (2009). *Үндэсний инновацын тогтолцоо бүрдүүлэх онол-аргазүйн үндэс (Монгол Улсын жишээн дээр)* (ScD докторын диссертаци). Улаанбаатар.
- Republic of Kazakhstan. (2002). *Law on innovation activities*.
- Schumpeter, J. A. (1993). *The theory of economic development* (Russian ed.). Moscow.
- Ukraine. (1997). *Law on innovation activities*.
- Швандер, В. А., & Горфинкель, В. Я. (2006). *Инновационный менеджмент*. Москва.

Инновацийн ангилал			
Код	Шалгуур	Код	Инновацийн төрөл, хэлбэр
1	Инновацийн биет хэлбэр	1.1	Нээлт, бүтээл, патент, ноу-хау, оновчтой санал
		1.2	Шинэ болон сайжруулан шинэчилсэн бүтээгдэхүүн
		1.3	Шинэ болон сайжруулан шинэчилсэн үйлчилгээ
		1.4	Дэвшилтэт технологи
		1.5	Шинэ дэвшилтэт стандарт, норматив
		1.6	Барааны тэмдэг, худалдааны тэмдэг, эмблем
		1.7	Удирдлага, зохион байгуулалт, худалдаа борлуулалтын шинэ арга
		1.8	Шинэ технологи, үйлдвэрлэл, удирдлагын процесс, хийц, бүтцийг тодорхойлсон баримт бичиг
2	Инновацийн шинж байдал	2.1	Техник-технологийн инновац
		2.1.1	Бүтээгдэхүүний инновац
		2.1.2	Процессийн инновац
		2.2	Экологийн инновац
		2.3	Эдийн засгийн инновац
		2.4	Нийгмийн инновац
		2.4.1	Нийгэм- улс төрийн инновац
		2.4.2	Төр-эрх зүйн инновац
		2.4.3	Нийгэм- соёлын инновац
3	Инновацийн шинэлэг байдал	3.1	Суурь /радикаль/инновац
		3.2	Сайжруулах инновац
		3.3	Хуурмаг инновац
4	Инновацийн шинэлэг байдлын цар хүрээ/ масштаб	4.1	Дэлхийн түвшинд шинэ
		4.2	Улс орны түвшинд шинэ
		4.3	Салбар, бүсийн хувьд шинэ
		4.4	Байгууллагын хувьд шинэ
5	Инновацийн хэрэглээний давтамж	5.1	Нэг удаагийн инновац
		5.2	Дахин давтагдах инновац
6	Инновацийн хэрэглээний нийгмийн хүрээ	6.1	Эдийн засгийн хүрээ:
		6.1.1	Үйлдвэрлэл:
		6.1.1.1	Материаллаг үйлдвэрлэл
		6.1.1.2	Үйлчилгээ
		6.1.2	Байгалийн нөөц ашиглалт, экологи
		6.1.3	Эдийн засгийн улсын сектор
		6.1.4	Хувийн сектор
		6.2	Нийгмийн хүрээ:
		6.2.1	Шинжлэх ухаан
		6.2.2	Боловсрол
		6.2.3	Соёл, урлаг
		6.2.4	Үзэл суртал, оюун санаа
		6.2.5	Нийгэм- улс төрийн үйл ажиллагаа
		6.2.6	Төрийн үйл ажиллагаа
7	Инновацийг нэвтрүүлсний үр дүн, үр ашгийн үзүүлэлтийн хэлбэр	7.1	Эдийн засгийн үр дүн, үр ашиг
		7.2	Шинжлэх ухаан-технологийн үр дүн, үр ашиг
		7.3	Экологийн үр дүн, үр ашиг
		7.4	Нийгмийн үр дүн, үр ашиг
		7.5	Хосолмол/ интеграль үр дүн, үр ашиг

Эх сурвалж: Оюунцэцэг Л. “Үндэсний инновацын тогтолцоо бүрдүүлэх онол-аргазүйн үндэс(Монгол улсын жишээн дээр)” Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (ScD)-ын зэрэг горилсон диссертаци, -УБ, 2009